



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/400

Есенбулаг сум

Тусгай зориулалтын агнуурын амьтныг
агнах гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.1, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.7} дэх заалтууд, Монгол улсын Засгийн газрын "Тусгай зориулалтаар 2025 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай" 242 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар угалз, тэх агнах, зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагч нарын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагч нартай "Агнуурын амьтныг агнах, барих" гэрээ байгуулж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгож, агнуурын амьтныг агнах зөвшөөрлийн үнэ, төлбөр хураамжийг хуулийн дагуу холбогдох дансанд төвлөрүүлж, агнуурын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчны газар (Д.Батмагнай)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

сарын 08 -ны өдрийн 11 цагаар
захирамжийн хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН 2025 ОНЫ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АГНУУРЫН
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЯЛАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

[illegible]